



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 10-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

*2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр, Лхагва гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 8
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	9 - 28

---

- 1. Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн болон 2023-2025 оны стратегийн хэрэгжилтийн тайланг хэлэлцэх* 9 - 16
- 2. “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэм батлах тухай” Улсын Их Хурлын 2017 оны 83 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл* 16 - 23
- 3. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийсэн нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцэх* 23 - 28
- 4. Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 01 дүгээр сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/* 28

***Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Төсвийн байнгын хорооны 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр  
/Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл***

Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 26 минутад Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.*

*Чөлөөтэй: Ц.Анандбазар, С.Ганбаатар, Л.Мөнхбаатар, Д.Өнөрболор, Ч.Хүрэлбаатар.*

***Нэг.Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн болон 2023-2025 оны стратегийн хэрэгжилтийн тайланг хэлэлцэх***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга Б.Сүх-Очир, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Гантогтох нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн болон 2023-2025 оны стратегийн хэрэгжилтийн тайланг Сангийн сайд Б.Жавхлан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан хариулж, тайлбар хийв.

Тайлантай холбогдуулан үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүд Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн болон 2023-2025 оны стратегийн хэрэгжилтийн тайланг сонсов.

*Уг асуудлыг 15 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр. “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэм батлах тухай” Улсын Их Хурлын 2017 оны 83 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Тогтоолын төслийг боловсруулах, өөрчлөн найруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир хариулж, тайлбар хийв.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн гараагүй болно.

**Г.Тэмүүлэн:** ““Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэм батлах тухай” Улсын Их Хурлын 2017 оны 83 дугаар “Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	3
Бүгд:	12

75.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийсэн нэр дэвшигчийн сонсголын тайланг хэлэлцэх***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан нэр дэвшигч Н.Энхбаяр, Ж.Дэлгэрсайхан, Н.Ууганбаатар, А.Энхбат, Р.Ринчинбазар, Л.Гангэрэл, Л.Отгонтуяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийсэн нэр дэвшигчийн сонголын тайлангийн талаарх танилцуулгыг сонгогч даргалагч, Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулна.

Тайлан болон нэр дэвшигчтэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн гараагүй болно.

Тайлан болон нэр дэвшигчтэй холбогдуулан үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн гараагүй болно.

▪ *Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн орон тооны бус гишүүдийг чөлөөлөх санал хураалт явуулав.*

**Г.Тэмүүлэн:** Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Далрайн Даваасамбууг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх гэсэн саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 5  
Бүгд: 12  
58.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Г.Тэмүүлэн:** Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Эрдэнийн Бямбажавыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх гэсэн саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 7  
Бүгд: 12  
41.7 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Г.Тэмүүлэн:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Г.Тэмүүлэн:** Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Эрдэнийн Бямбажавыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх санал хураалтыг дахин явуулъя.



Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Г.Тэмүүлэн:** Санал хураалт дэмжигдсэн тул Эрдэнийн Бямбажавыг зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх гэсэн саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Г.Тэмүүлэн:** Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Баярсайханы Баярдавааг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх гэсэн саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Г.Тэмүүлэн:** Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Атарбаатарын Энхжинг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх гэсэн саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Г.Тэмүүлэн:** Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Ланганы Отгонтуяаг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх гэсэн саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Г.Тэмүүлэн:** Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Дамирангийн Сувдааг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх гэсэн саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11

---

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Г.Тэмүүлэн:** Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Гүнсэнгийн Алтанзаяаг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн хараат бус гишүүнээс чөлөөлөх гэсэн саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

▪ *Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн орон тооны гишүүнээр томилох санал хураалт явуулав.*

**Г.Тэмүүлэн:** 1.Намжилдоржийн Энхбаярыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилох гэсэн саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Жамсрандоржийн Дэлгэрсайханыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилох гэсэн саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Нинжбатын Ууганбаатарыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилох гэсэн саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.


4.Амаржаргалын Энхбатыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилох гэсэн саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.



5.Равсалын Ринчинбазарыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилох гэсэн саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Лхагважавын Гангэрэлийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилох гэсэн саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Ланганы Отгонтуяаг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилох гэсэн саналыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

**Г.Тэмүүлэн:** Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсгол явуулсан талаарх тайланг бүхэлд нь дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилох асуудлыг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 19 минутад хэлэлцэж дуусав.*

**Дөрөв. Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 01 дүгээр сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, мөн хэлтсийн референт А.Хонгорзул нар байлцав.



Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Г.Тэмүүлэн:** “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 01 дүгээр сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 16 цаг 20 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 55 минут үргэлжилж, 19 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 73.7 хувийн ирцтэйгээр 16 цаг 21 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар”  
танхим  
15 цаг 26 минут

### БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Тэмүүлэн:** Байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн ирцийг Та бүхэнд танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанд Г.Амартүвшин гишүүн, С.Одонтуяа гишүүн, Д.Тогтохсүрэн гишүүн, Х.Баделхан гишүүн, Ц.Даваасүрэн гишүүн, Б.Пүрэвдорж гишүүн, Ж.Батжаргал гишүүн, Б.Жавхлан гишүүн, Ш.Раднаасэд гишүүн, Б.Чойжилсүрэн гишүүн, Ж.Батсуурь гишүүн, Ц.Сандаг-Очир гишүүд хүрэлцэн ирснээр, 13 гишүүн хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан бүрдсэн байна.

Ингээд 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Байнгын хорооны хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Та бүхэнд танилцуулъя.

**Нэгдүгээр асуудал.** Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан болон 2023-2025 оны стратегийн хэрэгжилтийн тайлан.

**Хоёрдугаарт,** “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэм батлах тухай” Улсын Их Хурлын 2017 оны 83 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

**Гуравдугаарт,** Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн нэр дэвшигчдийн хийсэн нэр дэвшигчийн сонголын тайлан хэлэлцэх.

**Дөрөвдүгээрт,** Байнгын хорооны тогтоолын төсөл буюу цаглавар батлах тухай гэсэн ийм дөрвөн асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай гишүүд байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа орцгооё.

---

### Нэг. Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн болон 2023-2025 оны стратегийн хэрэгжилтийн тайланг хэлэлцэх

---

Нэгдүгээр асуудал. Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан болон 2023-2025

оны стратегийн хэрэгжилтийн тайланг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Та бүхэнд танилцуулъя.

---

Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн талаарх тайлангийн хуралд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Сангийн сайд Болдын Жавхлан, Батсүхийн Сүх-Очир Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Лувсандоржийн Гантогтох Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Өрийн удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн гэсэн бүрэлдэхүүнтэй оролцож байна.

Ингээд хэрэгжилтийн тайлангийн танилцуулгыг Монгол Улсын сайд, Сангийн сайд Болдын Б.Жавхлан танилцуулна.

Б.Жавхлан сайдад микрофоныг өгье.

**Б.Жавхлан:** Төсвийн байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.2.14 дэх заалтад Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын тайлан Өрийн удирдлагын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг Төсвийн байнгын хороонд жил бүр тайлагнана гэж заасны дагуу Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны Стратегийн баримт бичгийн явцын тайланг бэлтгэн Та бүхэнд танилцуулж байна.

Уг стратегийн баримт бичгийн хүрээнд

- Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийг нэмэгдүүлэх;
- Засгийн газрын үнэт цаасыг төсөвт дарамт учруулахгүйгээр төлж дахин санхүүжилтийн эрсдэлийг бууруулах;
- Засгийн газрын өрийн удирдлагын тогтолцоог сайжруулж, орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх;
- Засгийн газрын дотоод үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих;
- Улсын стратегийн томоохон төслүүдэд Засгийн газрын өрийн баталгаа гаргах;
- Засгийн газрын өрийн удирдлагын ил тод байдлыг сайжруулах зэрэг үндсэн 6 зорилтыг тавьж ажиллаж байна.

Эдгээр зорилтын хүрээнд Засгийн газрын зүгээс Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан өрийн хязгаарыг баримталж, Засгийн газрын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг бууруулах, төсвийн алдагдал санхүүжүүлэхэд зориулж арилжааны нөхцөлтэй зээлийг авахгүй байх, барих, шилжүүлэх нөхцөлтэй концесс болон өрийн баталгааны үлдэгдлийг бууруулах зэрэг арга хэмжээ авсны үр дүнд Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийг дотоодын нийт бүтээгдэхүүнд

харьцуулсан харьцаа 2016 онд 78.8 байсан бол 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 44.3 хувь болж, 34 хувиар буураад байна.

Түүнчлэн Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт заасан зорилтуудтай холбогдох ажлуудын хүрээнд дараах гол арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлээ.

**Нэгдүгээрт,** Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийн үр ашгийг сайжруулах, төсөвт үзүүлэх төлбөрийн дарамтыг бууруулах арга хэмжээний хүрээнд Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Экспорт, импортын банктай 6 сарын турш хэлцэл хийж 2023 оны 08 дугаар сарын 17-ны өдөр Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийн 1 тэрбум ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд дэд гэрээнүүд гарын үсэг зурлаа.

Дэд зээлийн гэрээнүүдийг байгуулснаар **ЕРС**<sup>1</sup>[Engineering, Procurement, Construction] 2, 3 дугаар багцын ажлын зээлийн эргэн төлөлт болох 789.0 сая ам.долларын үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацааг дахин 7 жилээр хойшлуулж, 2023 оноос эхлэн зээлийн үндсэн төлбөрт 64.5 сая ам.доллар төлж эхлэх байсныг 13 сая доллар болгон бууруулж төсвийн дарамтыг багасгалаа.

Мөн 2018 оноос хойш хийгдэхгүй гацаанд ороод байсан **ЕРС2**, **ЕРС3** дугаар багцын ажлын санхүүжилт авах боломжийг бүрдүүлж, төслийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлээд байна.

---

<sup>1</sup> Томоохон, нарийн төвөгтэй дэд бүтцийн төслүүдийн барилгын ажилд хэрэглэгддэг гэрээний хэлбэр буюу түлхүүр гардуулах гэрээний нэг төрөл.

Түүнчлэн Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж байсан боловч бэлтгэл ажил хангагдаагүй импортыг нэмэгдүүлж, экспортыг дэмжихгүй төслүүдийг татгалзах зарчмыг баримтлан ажиллаж байна.

Тухайлбал, Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төлөвлөж байсан

-“Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх-2”,

-Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй “Тогтвортой мал аж ахуйг хөгжүүлэх төсөл”,

-Бүгд Найрамдах Польш Улсын “Хүнсний ногооны үйлдвэрлэл, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх төсөл”

-Бүгд Найрамдах Беларусь Улсын “Улаанбаатар хотын нийтийн зориулалттай орон сууцын цахилгаан шатыг шинэчлэх төсөл”-үүдээс татгалзаад байна.

**Хоёрдугаарт,** гадаад бондын дахин санхүүжилтийн арга хэмжээний хүрээнд энэ оны 01 дүгээр сард **“Century-2”** өнгөрсөн оны шүү. Өнгөрсөн оных шүү.

Өнгөрсөн оны 01 дүгээр сард “Century-2” өрийн зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлж, 650 сая ам.доллартой тэнцэх гадаад бондыг дахин санхүүжүүлсэн бөгөөд **“Гэрэгэ”** бондын 435.3 сая ам.долларын төлбөр болон **“Хуралдай”** бондын 207.5 сая ам.долларын төлбөрийг тус тус төлж барагдуулсан.

Түүнчлэн хугацаанд болоод байсан **“Хуралдай”** бондын үлдэгдэл

392.5 сая ам.долларын төлбөрийг дахин санхүүжилт хийх, “**Century-3**” өрийн зохицуулалтын арга хэмжээг мөн өнгөрсөн оны 11 дүгээр сард амжилттай авч хэрэгжүүллээ.

Үүнд 350 сая ам.долларын “Century-3” бондыг 7.875 хувийн хүүтэйгээр 5.5 жилийн хугацаатайгаар олон улсын санхүүгийн зах зээл дээр арилжаалж 2024 оны 03 дугаар сард эргэн төлдөг хуваарьтай “Хуралдай” бондын бондын өр төлбөрийг шийдвэрлэлээ.

Мөн 2023 онд “Гэрэгэ” бондын 82.0 сая ам.доллар, “**Номад**” бондын хоёр дахь зах зээлийн буцаан худалдан авалтаар 22.0 сая ам.доллар, нийт 104. сая ам.долларын төрийн сангийн мөнгөн хөрөнгөөр төлж барагдуулан гадаад бондын үлдэгдлийг бууруулаад байна.

Олон улсын зээлжих зэрэглэлийг тогтоогч **Fitch Ratings**, **Moody's**, **STANDARD & POOR'S** агентлагуудтай тогтмол хамтран ажиллаж, дэлхийн олон орны зээлжих зэрэглэл буурч байгаа энэ үед Монгол Улсын зээлжих зэрэглэлийн тогтвортой түвшинд хадгалж, улмаар 2021 оны 3 дугаар сард **Moody's** агентлагийн Монгол Улсын зээлжих зэрэглэлийг “**B3 сөрөг**” зэрэглэлээс “**B3 тогтвортой**” түвшин рүү нэмэгдүүлсэн билээ.

Мөн **Fitch** болон **STANDARD & POOR'S** агентлагуудтай 2020 оны 07 дугаар сард уулзсан уулзалтын үр дүнд Монгол Улсын зээлжих зэрэглэлийг “**B тогтвортой**” түвшинд хэвээр хадгалж үлдээд байна.

**Гуравдугаарт**, Засгийн газрын өрийн зохицуулалтын үйл ажиллагаанд үүсмэл арга хэрэгслийг нэвтрүүлэх ажлын хүрээнд “**Глобал сан**” Холбооны

Бүгд Найрамдах Герман Улстай хамтран өөрийн эрүүл мэнд чиглэлээр своп хэлэлцээр хийх үйл ажиллагааг эхлүүлээд байна.

Уг своп хэлэлцээрийн хүрээнд Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Сэргээн босголтын зээлийн банкнаас авсан **229.0** сая еврогийн зээлийн өргөн төлөлтийг цуцалж, Монгол Улсын Засгийн газар уг эх үүсвэрээр ДОХ, сүрьеэ болон хумхаа өвчний эсрэг төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх үүргийг хүлээх бөгөөд уг хэлэлцээрийг хэрэгжүүлэхээр хамтарсан ажлын хэсэг гарган ажиллаж байна.

Орон нутгийн өрийн удирдлагын чадавхыг бэхжүүлэх, болзошгүй өр төлбөрийн эрсдэлээс сэргийлэх арга хэмжээний хүрээнд Өрийн удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7 дахь хэсэгт аймаг, нийслэлийн Засаг даргын үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэхтэй холбогдсон журмыг Сангийн яамнаас боловсруулж, Засгийн газар баталж мөрдүүлнэ гэж заасны дагуу Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 199 дүгээр тогтоолоор Нийслэлийн үнэт цаас гаргах, арилжаалах, мэдээлэх журмыг баталж нийслэлээс дотоодын зах зээлд үнэт цаас гаргах эрх зүйн орчныг бүрдүүлээ.

**Дөрөвдүгээрт**, нэгдсэн төсвийн гүйцэтгэл ашигтай, төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл харьцангуй сайн байгаа зэргээс шалтгаалан 2023 оны Засгийн газрын дотоод үнэт цаас арилжаалах шаардлагагүй гэж үзэж байна.

Засгийн газрын зүгээс төсвийн алдагдал болон төрийн сангийн мөнгөн хөрөнгийн дутагдлыг нөхөх зорилгоор 2024 оны Засгийн газрын дотоод үнэт цаасыг зохистой хэмжээгээр олон нийтэд

нээлттэй нэгдсэн зах зээл дээр арилжаалах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

**Тавдугаарт**, “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгасан стратегийн чухал ашиглал бүхий төсөл болох Чойбалсан дулааны цахилгаан станцад суурилагдсан хүчин чадлыг **50 мегаватт**-аар нэмэгдүүлэх, өргөтгөх төслийн санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор Улсын Их Хурлын 2023 оны 90 дүгээр тогтоолоор тус төслийн хүрээнд 2024 онд Засгийн газрын өрийн баталгаа гаргахаар шийдвэрлэсэн.

Уг төсөл амжилттай хэрэгжсэнээр Дорнод, Сүхбаатар аймгийн **36** сум, багийн **25, 139** айл өрх, **3133** аж ахуйн нэгж, албан байгууллага, уул уурхайн **13** ордын олборлох үйлдвэрүүд тасралтгүй, найдвартай эрчим хүч хүчээр хангагдаж, Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас импортоор авдаг эрчим хүчний хэмжээг жилд **438 сая киловаттаар** бууруулах ач холбогдолтой юм.

Засгийн газрын зүгээс мөн зорилтын хүрээнд болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг бууруулах зорилгоор 2023 онд вексель өрийн бичиг гаргахгүй байх, шинээр барих, шилжүүлэх нөхцөлтэй концессын гэрээ байгуулахгүй байх бодлогыг тууштай баримтлан хатуу баримталж ирлээ.

**Зургадугаарт**, Засгийн газрын өрийн ил тод байдлыг сайжруулах, өрийн статистик товхимлийг Сангийн яамны цахим хуудсанд улирал бүр олон нийтэд ил тод байдлаар нийтэлж байна.

Тус өрийн товхимолд Засгийн газрын өрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллүүдийг оруулснаас гадна улсын секторын өрийн статистикийг Олон Улсын Валютын Сангаас гаргасан

аргачлалын дагуу хагас жил бүр тайлагнаж байгаагаараа онцлогтой байна.

Засгийн газрын Өрийн удирдлагын стратегийн баримт бичигт тавьсан зорилт, арга хэмжээг авч хэрэгжүүлснээр 2023 оны 3 дугаар улирлын байдлаар Засгийн газрын өрийн багцын жигнэсэн дундаж хүү **3.8** хувь, эргэн төлөгдөх дундаж хугацаа **8.7** жил, хүү шинэчлэгдэх дундаж хугацаа **7.7** жил, гадаад өрийн Засгийн газрын өрд эзлэх хувь **95** хувьтай тэнцэж байна.

Засгийн газрын зүгээс хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийг түлхүү ашиглаж, арилжааны нөхцөлтэй хугацаа дууссан өр төлбөрт өрийн зохицуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлснээр Засгийн газрын өрийн багцын эргэн төлөгдөх хугацаа болон хүү шинэчлэх дундаж хугацаа 2022 оны түвшнээс уртассан үзүүлэлттэй байна.

Хувьсах хүүтэй зээлүүдийн суурь хүү болон **SOFR**<sup>2</sup>[Secured Overnight Financing Rate] хүү нэмэгдсэнээр өрийн вакцин жигнэсэн дундаж хүү нь нэмэгдсэн бол 2022 онд нэгдсэн төсвийн алдагдал төлөвлөсөн хэмжээнээс бага гарсан.

2023 онд нэгдсэн төсвийн тэнцэл ашигтай байгаа зэргээс шалтгаалан Засгийн газрын дотоод үнэт цаас бага хэмжээгээр арилжаалсан тул дотоод өрийн Засгийн газрын өрд эзлэх хувь хэмжээ бага хэвээр байна.

Засгийн газрын зүгээс цаашид Засгийн газрын 2023-2025 оны стратеги баримт бичигт туссан бодлогын зорилтууд, хэрэгжүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бөгөөд стратегийн хэрэгжилтийг Засгийн газар,

<sup>2</sup> Төрийн сангийн үнэт цаасаар барьцаалагдсан бэлэн мөнгө зээлэх өртгийн хэмжүүр.

Улсын Их Хуралд тогтмол тайлагнан ажиллах болно.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Тэмүүлэн:** Танилцуулга хийсэн Б.Жавхлан сайдад баярлалаа.

Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан болон 2023-2025 оны стратегийн хэрэгжилтийн тайлантай холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу?

Ц.Даваасүрэн гишүүнээр тасалъя.  
Ц.Даваасүрэн гишүүн асуулт асууя.

**Ц.Давасүрэн:** Баярлалаа.

Энэ дээр би нөгөө өрийн шалгуур үзүүлэлтүүд байхгүй болохоор тодруулж асуух гээд байгаа юм шүү.

Дотоодын нийт бүтээгдэхүүнтэй харьцуулсан харьцаа, экспортод харьцуулсан харьцаа, төсвийн үзүүлэлтэд харьцуулсан харьцааг хэлж өгөөч.

Өрийн 7 шалгуур үзүүлэлтийнхээ энэ 3-ыг.

Би зүгээр нэг ийм юман дээр бас анхаараач гэж. Тэгээд өдөр ч бас би Засгийн газрын хурал дээр хэлсэн юм. **STANDARD & POOR'S**. Манайх ингээд **“В тогтвортой”** гээд явж байгаа юм.

Гэтэл манай энэ өр дээр муу харагдуулж байгаа юм бол Оюу Толгойн манайд зээл болгочоод байгаа энэ 12 тэрбум, 13 ч болчхоод байна уу, тэрбум долларын асуудал байгаа юм.

Энэ чинь Засгийн газрын өрийн удирдлага, төрийн өмчийн компаниудыг

оруулж тооцох ёстой байдаг. Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийг.

Ингээд харах юм бол энэ өрийг оруулж тооцвол нийт Монголын гадаад өрийн 50 хувь энэ байгаад байдаг.

Тэгээд биднийг зээлжих зэрэглэлийн хувьд хамгийн муу харагдуулаад байдаг.

Гэтэл үнэн чанартаа энэ зээл байлгаараа төлж байгаа эрсдэл багатай зээл байгаа юм. Зарим үзүүлэлтээр энэ орчихсон яваад байгаа юм билээ.

Тийм учраас би тэгээд байгаа юм.

2013 онд зээлийн үзүүлэлтийг тодорхойлохдоо дэд бүтцийн салбаруудын зээлийг. Төмөр зам, Багануурт авсан зээлүүд, уул, уурхайд авсан зээлүүд.

Мөн эрчим хүчинд авсан ТЭЦ IV зээлүүдийг хассан байдлаар дэд бүтцийн зээлүүдийг хасаж өрийн шалгуур үзүүлэлтүүдээ гаргах тухай бас нэг ийм зохицуулалт хийж байсан юм.

Тэгэхээр миний хэлэх гээд байгаа зүйл бол энэ Оюу Толгойн гадаад өр Монгол Улсын нийт өрд тооцогдоод байгаа энэ 13, 14 тэрбум долларын асуудлыг ер нь хасаад явбал яадаг юм бэ?

Тийм эрх зүйн зохицуулалт хийж ер нь болохгүй юу. Зарим дээр энэ чинь орчихсон яваад байгаа харагдаад байгаа.

Тэгэхдээ Монгол Улсын нийт өрд орчхож байгаа юм. Монголбанкнаас авч байгаа үзүүлэлт дээр орчихсон явна лээ. Монгол Улсын нийт өр дотор.

Тэгээд энэ тэртээ тэргүй байгалийн баялгаараа төлөгдчихөөр эрсдэл багатай зээл учраас үүнийг хасаад явъя. Тийм шийдвэрийг бид гаргах бололцоо юу байна гэж би бодоод байгаа юм.

Нөгөө талаараа энэ тэртээ тэргүй л нөгөө өр зээл гэхихсэн учраас яах аргагүй бичигдэхээс өөр арга байхгүй. Тэр тусмаа төрийн өмчийн оролцоотой.

Тэгээд энэ асуудлыг нэг мөр хэдүүлээ бас нэг эрх зүйн зохицуулалт талаас нь шийдээд, ингээд Монгол Улсын нийт өрөөс хасаад явах юм бол манай өрийн үзүүлэлт сайжирч харагдах нэг ийм зүйл байгаа юм гэдгийг би санал болгож хэлье.

**Г.Тэмүүлэн:** Ц.Даваасүрэн гишүүний асуултад хариулъя. Сангийн сайд Б.Жавхлан сайдын микрофоныг өгье.

**Б.Жавхлан:** Тийм. Ц.Даваасүрэн гишүүний асуултад хариулъя.

Ер нь санаа нь зөв өө. Ер нь үе үеийн Сангийн сайд нар аль болох эрсдэлээ мэдээж хамгийн өндөр эрсдэлтэйгээр тооцож шийдвэрээ дунд, урт хугацаанд гаргаж төлөвлөж явах нь хамгийн зөв байгаа юм.

Энэ хугацаанд, бидний цаг үед юу тохиолдож байна вэ гэхээр одоо тэр 2016 онд хэрвээ тэр Засгийн газрын өр, дотоодын нийт бүтээгдэхүүний харьцаа 78.8 гээд бараг 80 шүргэх үед хэрвээ энэ аргачлалаар тооцсон бол ингээд Засгийн газрын өр нь бараг 100 хувь даваад гараад явчих.

Тэр үед аргачлалууд нь солигдоод явсан юм билээ.

Одоо байдал арай өөр болж ирж байна.

Засгийн газар улсын секторын өрийн даац, эрсдэл даах чадвар бас харьцангуй өндөр болж ирж байгаа.

Ийм үед бид хоёр тал руу бичиг чиглэлүүдээр явах хэрэгтэй.

Өөрөөр хэлбэл одоо Монгол Улсын нийт өрийг гурван багцад хувааж байгаа.

- Засгийн газрын өр,
- Улсын секторын өр,
- Хувийн секторын өр гээд.

Энэ гурав бүгд нийлээд Монгол Улсын нийт өр болж байгаа.

Сая Ц.Даваасүрэн сайдын хэлж байгаа тэр Оюу Толгой болон Эрдэнэт гээд бусад улсын секторын үйлдвэрүүдийн өр улсын секторт ороод, яг нөгөө дотоодын нийт бүтээгдэхүүний эрсдэлд тооцдог Засгийн газрын өрөнд хараахан орохгүй байгаа. Орж тооцохгүй байгаа. Өрийн удирдлагын тухай хуулиараа.

Тэгэхээр цаашдаа улсын секторын өрөндөө ч бас оруулж тооцохгүй байх талын юм бодох цаг хугацаа одоо л ирж байна гэж харж байна.

Тэгээд энэ дээр цаашаа бид судалж, бас хамтарч ажиллая. Тийм.

**Г.Тэмүүлэн:** Баярлалаа.

Тайлантай холбогдуулаад гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Тайлантай холбогдуулж үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/



Ингээд Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан

болон 2023-2025 оны стратегийн хэрэгжилтийн тайланг хэлэлцэж дууслаа.

Хоёр дахь асуудалдаа орцгооё.

---

**Хоёр. “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэм батлах тухай”  
Улсын Их Хурлын 2017 оны 83 дугаар тогтоолд  
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын  
тогтоолын төсөл**

---

“Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэм батлах тухай” Улсын Их Хурлын 2017 оны 83 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай асуудал буюу Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 01 дүгээр сард “Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэм батлах тухай” Улсын Их Хурлын 2017 оны 83 дугаар тогтоолын хавсралтыг өөрчлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Та бүхэнд Байнгын хорооны тогтоолын төслийг тараасан байгаа.

Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

“Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай”.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 83 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрмийг хавсралтаар өөрчлөн баталсугай.

Энэ тогтоолыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн ийм тогтоолын төсөл байгаа.

Тогтоолын төслийг уншиж танилцууллаа.

Гишүүдэд тогтоолын төслийг тараасан байгаа.

Тогтоолын төслийг боловсруулах, өөрчлөн найруулах талаар ажилласан ажлын хэсгийн ахлагч Ц.Сандаг-Очир гишүүн ажлын хэсгийн санал, дүгнэлтийг уншиж танилцуулна.

Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье. Ажлын хэсгийн ахлагч.

**Ц.Сандаг-Очир:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 11 дүгээр тогтоолоор Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэмд өөрчлөлт оруулах санал, дүгнэлт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.

Ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир миний бие ахлан, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан, С.Одонтуяа нар ажиллалаа.

Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 83 дугаар тогтоолоор Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрмийг баталж, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2018 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 10 дугаар тогтоолоор Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүдийг томилон ажиллуулж байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэмд зөвлөл нь дарга болон орон тооны бус 8 гишүүнээс бүрдэхээр заасан байгаа.

Тэгвэл Улсын Их Хурал 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг баталж, тус хуульд зөвлөл нь 7 гишүүнээс бүрдэх бөгөөд Төсвийн байнгын хороо нээлттэй сонгон шалгаруулалтаар хүн тус бүрээр шалгаруулж, Улсын Их Хуралд томилж чөлөөлөхөөр заасан.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд зөвлөлийн чиг үүргийг өргөжүүлэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг тухайн хуульд нийцсэн эсэх, төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг хангасан эсэх, улсын төсөвт үзүүлэх нөлөөлөл, ачааллын талаар судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах болон Төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл боловсруулахад баримтлах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалыг боловсруулах үүрэгтэйгээр Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дэргэд ажиллахаар заасан.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд оруулсан өөрчлөлттэй

холбогдуулан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэмд өөрчлөлт оруулах шаардлагатай тул “Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1-д заасны дагуу боловсруулсан болно.

**Нэг.** Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэмд дараах өөрчлөлтийг оруулахаар төсөлд тусгасан болно. Үүнд:

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16<sup>1</sup>-д заасан чиг үүргийн хүрээнд

- эдийн засгийн төсөөлөл, таамаглал хийх,
- төсвийн болон хөгжлийн бодлогын тогтвортой байдалд шинжилгээ хийх,
- төсөвт учрах эрсдэлийн шинжилгээ хийх

гэсэн гурван чиглэлээр зөвлөлийн хийх ажлын чиг үүргийг нарийвчлан тодорхойлох.

**Хоёр.** Зөвлөл хамтын удирдлагын зарчимд үндэслэн үйл ажиллагаагаа явуулахаар тусгах.

Зөвлөл эдийн засгийн таамаглалын

- төсвийн эрсдэлийн,
- төсвийн тогтвортой байдлын,
- бодлогын нөлөөллийн шинжилгээний

гэсэн гурван тайланг сар, улирал бүрээр гарган хуралдаанаараа хэлэлцэж, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд танилцуулж, олон нийтэд мэдээлэх, хагас

жил тутам олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах.

Зөвлөл чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, судалгааг холбогдох төрийн байгууллага, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагаас гаргуулан авах.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэмд тусгагдсан Зөвлөлийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх үндэслэл Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд тусгагдсан тул дүрмээс хасах.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нийцүүлэн дүрэмд тусгагдсан зөвлөлийн ажлын албатай холбогдох зохицуулалтыг зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангаж, дэмжлэг үзүүлж ажиллах.

Төсвийн судалгааны нэгж тухайн ажлын албаны чиг үүргийг гүйцэтгэхээр тусгах.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрмийн зарим зохицуулалтыг холбогдох хуульд нийцүүлэн өөрчлөхөөр тусгасан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

“Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Х.Баделхан, С.Одонтуяа.

**Г.Тэмүүлэн:** Ажлын хэсгийн дарга Ц.Сандаг-Очир гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийн танилцуулсан санал, дүгнэлт болоод тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу?

Ц.Даваасүрэн гишүүн, Ж.Батжаргал гишүүд. Ж.Батжаргал гишүүнээр тасаллаа. Ц.Даваасүрэн гишүүн асуултаа асууя.

**Ц.Даваасүрэн:** Би энэ зөвлөл байгуулагдаж байхад бас нэг их дэмжээгүй юм.

Яагаад гэвэл ер нь ихэнх парламент байнгын ажиллагаатай төсвийн нэгжтэй байдаг.

Түүнээс биш үүн шиг ийм орон тооны бус юм байдаггүй. Жишээлбэл, эд нар өөрсдийнхөө хийж чадахгүй ажлыг энд байж байгаа юм л даа.

Макро эдийн засгийн загварчлал гаргаад эд нар макро эдийн засгийн төсөөлөл, таамаглал хийнэ гэж хэзээ ч байхгүй.

Тийм учраас бусад орны парламентууд Улсын Их Хурлын гишүүддээ тусламж үзүүлэх зорилгоор төсвийн албатай байдаг. Тэгээд тэр албаны хуулийг нь би хийгээд өргөсөн байгаа. 2014 онд байна уу даа.

Тэгээд түүний шиг Улсын Их Хуралдаа тусалдаг байх ёстой юм. Тэр төсвийн алба.

Жишээлбэл, төсөв өргөн баригдсанаас хойш Их Хурлын хийх ажил.

Гэтэл өнөөдөр манайх Сангийн яамныхан энд ирээд энэ тооцоо, нэгтгэлийг нь бид нарын гаргасан

саналын дагуу хийгээд сууж байгаа. Энэ дээр алдаа гарч байсан тохиолдол бий.

Тэр үед ямар асуудал үүссэн гэхээр өргөн барьснаас хойш төсөв алдаатай баталсан юм гарсан. 4, 5 саналыг хоёр удаа оруулчихсан юм гарсан.

Гэтэл хариуцлагаа хэн нь хүлээх вэ болсон.

Өргөн барьснаас хойш Их Хурал гэсэн. Их Хуралд тэр бүтэц нь байхгүй.

Бусад бүх Их Хуралд бий. Яагаад гэвэл төсөв гэдэг бол Их Хурлын онцгой хийх ёстой нэг бүтээгдэхүүн байдаг. Төсөв батлах гэдэг бол.

Тийм учраас та нар ингээд бусад орны парламент дээр очоод үзвэл бүгдээрээ төсвийн албатай байгаа.

Тэр төсвийн алба нь тэр Засгийн газраас оруулж ирж байгаа макро эдийн засгийн төсөөллүүд, тэр үнэ ханш, инфляц энэ бүгдийг чинь тэр төсвийн алба нь хянаад энэ зөв, буруу юу гээд сууж байдаг.

Оруулж ирж байгаа төсвийн бүх тоонуудыг чинь тэр алба нь зөв үү, буруу юу гээд сууж байдаг.

Их Хурлын гишүүдийг төсвийн талаар үг хэлэхэд нь хажууд нь зөвлөөд зогсож байдаг. Тэр улсууд тэр чинь тэр төсвийн албаны шинжээч нар байдаг.

Бид үндсэндээ мэргэжлийн бус мөртлөө тэгээд л мэдэмхийрээд л зогсож байгаа шүү дээ. Тэд нарын туслалцаагүйгээр.

Тийм учраас төсвийн албыг нь байгуулаад явах нь Их Хуралд хэрэгтэй.

Бүх орны парламент тийм байна. Гэтэл манайд байхгүй. Манай Их Хурал ямар вэ гэвэл шалдан Их Хурал.

Энэ Их Хурлын гишүүдэд тусалдаг бүтцүүд нь байхгүй. Зүгээр л нэг мундаг улсууд. Ерөөсөө бүгдийг мэддэг.

Бусад орны парламент чинь чиглэл чиглэлээрээ тэр албууд нь байгаад байна шүү дээ.

Ялангуяа төсөв батална гэдэг Их Хурлын онцгой бүрэн эрхэд байдаг учраас тэр алба нь байж байдаг юм.

Тэгж байж тэр макро эдийн засгийн төсөөлөл дээр, энэ төсөв дээр Их Хурал дүгнэлтээ гаргаж явдаг.

Гэтэл орон тооны бус, хариуцлага хүлээхгүй, зөвлөмж гаргадаг нэг ийм юм байгуулаад л ингээд л хаячхаж байгаа байхгүй юу. Тэд нар нь цалин авна. Тэгэхдээ тэд нарын чадавх нь хүрэхгүй.

Тэр бусад орны төсвийн албадын ажилчид нь бүр маш өндөр түвшний мэргэжилтнүүдээс бүрдсэн байдаг.

Би уг нь 2012 онд үүнийг чинь байгуулах гээд оролдоод 5, 6 хүн авчирсан юм. Одоо юу болсныг нь мэдэхгүй. Одоо аягүй бол байхгүй болсон байх.

Тэр улсууд нь байдаг, төсвийн шинжилгээний албатай, хууль нь байж байгаад хэлэлцчихвэл уг нь Их Хурал нэг ажлаа бүрэн хийдэг болох гээд байгаа байхгүй юу.

Тэгээд тэр төсвийн нэгтгэлийн програмуудыг Их Хурал дээрээ авчраад өргөн барьснаас хойш төсвөө өөрсдөө хийх ёстой, Их Хурал.

Одоо бид чинь Сангийн яамтайгаа холилдчихоод, Засгийн газартайгаа холилдчихоод энд төсөв хэлэлцэж батлаад байгаа байхгүй юу.

Үүнийг Г.Тэмүүлэн дарга анхаараад. Энэ өргөн барьснаас хойш Их Хурлын ажил шүү, Засгийн газар оролцох ёсгүй шүү гэдгийг нэг бодоод үүнийг нь уг нь Их Хуралдаа хэдүүлээ хийгээд өгчихмөөр байгаа юм.

Тэгж байж Их Хурал байна шүү дээ, яг жинхэнэ утгаараа энэ төсөв дээр ажилладаг болно.

Тэгэхгүй бол арван хэдэн хүнтэй төсвийн ажлын хэсэг байгуулаад төсөв дээр шинжилгээ, судалгаа хийгээд, дүгнэлт хийгээд төсөв батална гэдэг бол дутуу хагас л юм.../минут дуусав/

**Г.Тэмүүлэн:** Нэмж дахиад минут авах уу? Ц.Даваасүрэн гишүүнд 1 минут өгье.

**Ц.Даваасүрэн:** Тэгж хэлэлцэж баталдаг болох юм бол одоо ёстой нөгөө нэг бүх бодлоготойгоо төсвөө уялдуулдаг тийм болох байгаа юм.

Тэгээд ер нь Төсвийн шинжилгээний алба төсвийн асуудлаар бүхий л түвшинд мөн дүгнэлт гаргадаг байх ёстой. Төсвийн хэрэгжилтүүд дээр тэр.

Бид хууль батлаад л орхичхож байна шүү дээ. Тэгээд л аудитад даатгасан болоод л.

Энэ шинжилгээний алба жишээлбэл зарим асуудал дээр бас төсвийн хэрэгжилтийн явц дээр тодорхой хяналтын чиг үүрэгтэй байдаг.

Тэгэхээр энэ төсвийн албыг нь л бид Их Хуралдаа байгуулж өгмөөр байгаа юм даа гэдгийг л би дахин дахин хэлье.

**Г.Тэмүүлэн:** Ц.Сандаг-Очир гишүүн хариулах уу? Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

**Ц.Сандаг-Очир:** Ц.Даваасүрэн гишүүн яг чухал, одоо энэ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрмийн гол өөрчлөлтийн нэг хэсгийг хөндөж байна.

Өнгөрсөн жилийн төсвийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтөөр яг бид таны ярьж байгаа шиг одоогийн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг орон тооны бусаар ажиллуулж байгааг орон тооны болгож ажиллуулахаар.

Тэр нь өөрөө Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дэргэд ажиллахаар, мэргэжлийн хүмүүсийг ажиллуулахаар.

Энэ мэргэжлийн улсуудыг нь нээлттэй сонгон шалгаруулалтаар, сонсголоор сонгон шалгаруулж, Улсын Их Хурлаар оруулж эцэслэн батлахаар өөрчилж өгсөн.

Нөгөө талаар зөвлөлийн хажууд Улсын Их Хурлын Тамгын газрын бүтцэд бас Төсвийн байнгын хорооны дэргэд судалгааны нэгжийг байгуулахаар өөрчилж өгсөн.

Одоо 2 хүний орон тоотой нэг судалгааны алба гэж яваа. Үүнийг өргөжүүлээд судалгааны нэгж гээд 5 хүртэл хүний бүрэлдэхүүнтэй судалгааны нэгж байгуулна.

Энэ судалгааны нэгж нь зөвлөлийн гишүүдийг мэдээллээр хангах.

Сангийн яамнаас өргөн баригдсан төсвийн хуулийн төсөл дээр дүн шинжилгээ хийх, судалгаа хийх, тооцоо судалгаа хийх, зөвлөлийн гишүүдийг мэдээллээр хангах ийм чиг үүрэг бүхий судалгааны нэгж байгуулагдахаар ингээд дүрэмд өөрчлөлт ороод явж байгаа гэдгийг бас хэлье.

**Г.Тэмүүлэн:** Ц.Даваасүрэн гишүүн нэмж тодруулъя.

**Ц.Даваасүрэн:** Тийм. Энэ уг нь бусад Их Хурлуудад байдаг төсвийн албаных нь ажил үүргүүдийг нь оруулсан юм билээ.

Тэгэхдээ ийм бүтцээр хийдэггүй юм. Тэр чинь бараг институт шиг юм байдаг байхгүй юу.

Ер нь тэгээд макро эдийн засгийн загварчлал хийж судалгаа хийнэ гэдэг чинь 5 хүний хийх ажил биш шүү дээ. Бүх салбарын.

Хуучин Төлөвлөгөөний комисс гэж байлаа шүү дээ. Түүний шиг л энэ чинь бүх салбарын тоон үзүүлэлтүүдээр ажилладаг, тэр бүх салбарын төсөв дээр ажиллаж чаддаг тийм баг байна гэдэг чинь бол хуучин Их Хурал дээр нэг судалгааны алба гээд Их Хурал бас нэг тийм судалгаа хийдэг ийм албатай болоод овоо хөл дээрээ бэхжээд явж байсан. Одоо энэ нь сулраад унаж байгаа юм билээ.

Тэр төсвийн алба гэдэг чинь бараг Сангийн яам шиг Их Хурлын сангийн яам байдаг байхгүй юу.

Тийм учраас үүнийг л хэдүүлээ хийж байж энэ Их Хурал яг жинхэнэ утгаараа ажилладаг болно.

Тэгээд тэр оруулж ирж байгаа макро эдийн засгийн үзүүлэлтээр нь бид өөрсдөө тэд нарын аманд автах биш бид өөрсдөө тэрийг хийдэг байх ёстой байхгүй юу. Статистик үзүүлэлтүүдийг гаргадаг байх ёстой.

**Г.Тэмүүлэн:** Ц.Даваасүрэн гишүүн 2014 онд Төсвийн албаны эрх зүйн байдлын тухай гээд хуулийн төслийг өргөн барьж байсан.

Тэгээд хуулийн төслийн гол үндсэн агуулга нь төсвийн алба нь улсын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, түүнтэй холбоотой асуудлаар яг энэ мэргэжлийн судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргаж, Улсын Их Хурлын үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллага байхаар оруулж өгч байгаа.

Одоо Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийнхаа дагуу Төсвийн зөвлөлөө нэгдүгээрт орон тооны бус байсныг орон тооны болгож аваад, тухайн хуульд хийснээрээ Төсвийн тогтвортой байдлын зөвлөл доороо бас нэг тодорхой судалгааны нэгжтэй буюу төсвийн албатай байхаар эхний ээлжид төсөвтөө багтаагаад 7 зөвлөлийн гишүүн дээр нэмэх нь 5 судлаач байхаар оруулж өгч байгаа.

Одоо бид дахиад эрх зүйн орчин талаасаа илүү төсвийн албыг бэхжүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа.

Тэгэхээр би нэгэнтээ Улсын Их Хуралд өргөн баригдсан байгаа Ц.Даваасүрэн гишүүний Төсвийн албаны эрх зүйн байдлын тухай хуульд саяын Төсвийн тогтвортой байдлын зөвлөл болоод одоо байгаа Төсвийн судалгааны нэгж албаны энэ үүрэг концепцыг нэгтгээд өөрчлөн найруулаад хаврын чуулганаар өргөн батлаад бүрэн гүйцэт

хийгээд явъя гэсэн төлөвлөгөөгөөр ажиллаж байгаа.

Өнөөдөр бидний одоогийн байгаа эрх зүйн байдлын хүрээнд ч гэсэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүд орон тооны болоод Улсын Их Хурлаас томилогддог болж байгаа нь нэг талдаа статусын хүрээнд төрийн тусгай албан хаагч Улсын Их Хурлаас томилогдож байгаа төрийн дээд нэг талдаа албан тушаалтан болж гарч ирж байгаа.

Тэгэхээр энэ байгууллага нэг талдаа мэргэжлийн сайн судлаач мэргэжлийн энэ хүмүүс маань доороо мэргэжлийн судалгааны төсвийн албатай байх зайлшгүй шаардлага байгаад байгаа.

Тэгээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл ч тэр, Төсвийн алба ч тэр аль аль нь Улсын Их Хуралд бүрэн дүүрэн туслалцаа үзүүлэх, төсвийн чиглэлээр мэргэжлийн судалгаа, шинжилгээ хийдэг үүрэг чиглэлтэй байх дахиад нэмэлт, өөрчлөлтүүд орох шаардлагатай байгаа.

Тэгээд би энэ асуудлыг таны өргөн баригдсан хуулийн хүрээнд нэмэлт, өөрчлөлтийг нь оруулаад батлуулаад явъя гэсэн төлөвлөгөөтэйгөө байгаа.

Эрх зүйн шинэчлэлийн асуудал цаашдаа энэ 3 сар хүртэл үргэлжлээд, ингээд 3 сард хаврын чуулганаар эцэслээд батлаад явъя.

Эцсийн бүтэц, зохион байгуулалт засаглал тогтолцоотой холбоотой эцсийн өөрчлөлтийг 3 сардаа эцэслээд батлаад явах ийм төлөвлөгөөтэй байна л гэж харж байгаа.

Та тэгээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүд бас орж

ирэхээр энэ дүрмийн өөрчлөлт ерөнхийдөө таны өргөн баригдсан хуулийн төсөлтэй одоо өргөн баригдаж байгаа тогтоолын төслүүд маань нэг талдаа 3 сард явахад нэг бодлогын баримт бичиг болоод явахаар л ийм концепц дээр бид өөрчлөлтүүдийг хийгээд чиглүүлээд явж байгаа гэдэг мэдээллийг нэмж хэлэх байна.

Тэгээд Ц.Даваасүрэн гишүүнтэй ерөнхийдөө концепц, агуулгын хувьд бид бүрэн дүүрэн нийцэж, яг энэ төсвийн ил тод байдал болоод төсвийн тогтвортой байдлыг бий болгох, энэ засаглал, бүтэц орон тоо, тогтолцоог бүрэн дүүрэн болгох ёстой гэдэг дээр санал нийлж байна.

Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу? Алга байна.

Ингээд ““Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэм батлах тухай” Улсын Их Хурлын 2017 оны 83 дугаар “Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэдгээр санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Гишүүд анхааралтай байгаарай.

Санал хураалт 75.0 хувиар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн дарга, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир гишүүн танилцуулна.

““Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүрэм батлах тухай” Улсын

Их Хурлын “Тогтоолын хавсралтыг өөрчлөн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Дараагийн асуудалдаа орёе.

---

**Гурав. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийсэн нэр дэвшигчийн сонголын тайланг хэлэлцэх**

---

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчтэй хийсэн нэр дэвшигчийн сонголын тайланг хэлэлцэж эхэлье.

Сонголын тайлангийн талаарх танилцуулгыг сонсгол даргалагч миний бие танилцуулна.

Та бүхэнд сонсгол явуулсан талаарх тайланг уншиж танилцуулъя.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлд нэр дэвшигч нартай хийсэн нэр дэвшигчийн сонголыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 19/1 дүгээр зүйлийн 19/1.2 дахь хэсэгт зөвлөл нь 7 гишүүнээс бүрдэх бөгөөд Төсвийн байнгын хороо нээлттэй сонгон шалгаруулалтаар хүн тус бүрээр шалгаруулж Улсын Их Хурал энэ хуульд заасан журмын дагуу томилж чөлөөлнө.

Мөн Төсвийн байнгын хороо нь Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29, 30, 31 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 123-аас 127 дугаар зүйлд заасны дагуу нэр дэвшигчийн сонголыг зохион байгуулах гэж заасны дагуу Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 131 дүгээр зүйл, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 123-аас 127 дугаар зүйлийг тус тус баримтлан зохион байгуулж дараах ажиллагааг явууллаа.

**Нэгдүгээрт**, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд Намжилдоржийн Энхбаяр, Жамсрандоржийн Дэлгэрсайхан, Нинжбатын Ууганбаатар, Амаржаргалын Энхбат, Равсалын Ринчинбазар, Лхагважавын Гангэрэл, Ланганы Отгонтуяа нар нь нэр дэвших хүсэлт гаргаж, Төсвийн байнгын хорооны 2023 оны 13 дугаар тогтоолоор баталсан Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвших тухай хүсэлтийн загварын дагуу материалаа бүрдүүлж Байнгын хороонд ирүүлсэн.

**Хоёрт**, 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дэгийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4-д заасны дагуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай тогтоолыг баталж, 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр нэр дэвшигчийн сонголыг зохион байгуулахаар сонсгол даргалагчаар миний бие ажилласан болно.

**Гуравт**, Сонголын бэлтгэл хангах хүрээнд нэр дэвшигчийн мэдээллийг Parliament.mn буюу Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулсан.



Сонсголын тов, сонсголд оролцогчийг бүртгэх хуудсыг байршуулсан. Зарыг Улсын Их Хурлын цахим хуудас, мөн холбогдох олон нийтийн хэвлэл мэдээллийн сайтууд, олон нийтийн үндэсний телевиз болон бусад телевиз, радиогоор 14 хоногийн хугацаанд давтамжтай хүргэсэн байгаа.

Мэдээллийн дагуу 4 оролцогч сонсголд оролцохоор хүсэлтээ ирүүлснийг Байнгын хороо, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хороо хүсэлтийг хүлээн авч огноо, цаг, минутаар бүртгэж баталгаажуулсан.

**Дөрөвт.** Төсвийн байнгын хорооны гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь хүрэлцэн ирснээр ирц бүртгэх бөгөөд 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн миний бие сонсголыг даргалж, Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Х.Баделхан, Ж.Батсуурь, Ц.Даваасүрэн, С.Одонтуяа, Б.Пүрэвдорж, Ш.Раднаасэд, Ц.Сандаг-Очир, Б.Чойжилсүрэн нарын гишүүд оролцлоо.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.1 дэх хэсэгт нэр дэвшигчийн сонсгол явснаас хойш ажлын хоёр өдрийн дотор сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайлан гаргана.

Тайланд сонсголын дүнд үндэслэн гаргасан нэр дэвшигч тухайн албан тушаалд тавих шаардлага хангасан эсэх дүгнэлт, түүний үндэслэлийг тусгаж холбогдох бусад мэдээллийг хавсран заасны дагуу сонсголд оролцсон гишүүд

2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайланг гаргалаа.

Ингээд тус тайлангаар:

***Нэгдүгээрт,*** нэр дэвшигч Намжилдоржийн Энхбаярыг сонсголын үр дүнд үндэслэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүний албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан гэж үзсэн.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

***Хоёрдугаарт,*** нэр дэвшигч Жамсранжавын Дэлгэрсайханыг сонсголын үр дүнд үндэслэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүний албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан гэж үзсэн.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

***Гуравдугаарт,*** нэр дэвшигч Нинжбатын Ууганбаатарыг сонсголын үр дүнд үндэслэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүний албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан гэж үзсэн.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

***Дөрөвдүгээрт,*** нэр дэвшигч Амаржаргалын Энхбатыг сонсголын үр дүнд үндэслэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүний албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан гэж үзсэн.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

**Тавдугаарт,** нэр дэвшигч Равсалын Ринчинбазарыг сонсголын үр дүнд үндэслэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүний албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан гэж үзсэн.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

**Зургадугаарт,** нэр дэвшигч Лхагважавын Гангэрэлийг сонсголын үр дүнд үндэслэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүний албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан гэж үзсэн.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

**Долдугаарт,** нэр дэвшигч Ланганы Отгонтуяаг сонсголын үр дүнд үндэслэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүний албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан гэж үзсэн.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Байнгын хорооны гишүүд Та бүхэн Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн талаарх сонсголын тайланг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсан Та бүхэнд баярлалаа.

Ингээд тайлан болон нэр дэвшигчтэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Нэрсийг авъя. Алга байна. /алх цохив/

Нэр дэвшигчтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт орж Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүдийг нээлттэй сонсголоор Улсын Их Хурлаас томилдог болсонтой холбогдуулан одоогийн орон тооны бус гишүүдийг чөлөөлөх саналтай байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүдийг Төсвийн байнгын хорооны 2018 оны 10 дугаар тогтоолоор өмнө томилж байсан байгаа.

Өмнө нь ажиллаж байсан орон тооны бус гишүүдийг чөлөөлөх асуудлаар санал хураалтыг явуулъя.

Гишүүн тус бүрээр явуулна.

Ингээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Далрайн Даваасамбууг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээс чөлөөлье гэсэн саналаар санал хураалтыг явуулъя.

Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт. Чөлөөлөхийг дэмжье гэснээр санал хураалт явуулж байна.

58.3 хувиар дэмжигдлээ.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн Эрдэнийн Бямбажавыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээс чөлөөлье гэсэн саналаар санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/ Гишүүд анхааралтай байгаарай.

Б.Пүрэвдорж гишүүн, Ц.Сандаг-Очир гишүүд санал хураалт эсрэг гарсан байна.

Горимын санал нэг нь гаргах уу? Ц.Сандаг-Очир гишүүн.

**Ц.Сандаг-Очир:** Сая санал хураалтаас хоцорсон байна. Санал маань эсрэг гарсан учраас санал хураалтыг хүчингүй болгож дахин санал хурааж өгөөч ээ.

**Г.Тэмүүлэн:** Өмнөх санал хураалтыг хүчингүй болгох горимын саналыг Ц.Сандаг-Очир гишүүн гаргасан тул Ц.Сандаг-Очир гишүүний горимын саналаар санал хураалтыг явуулъя. Өмнөх санал хураалтыг хүчингүй болгох. Гишүүд анхааралтай байгаарай. /алх цохив/

63.6 хувиар дэмжигдлээ.

Санал хураалт дэмжигдсэн тул Эрдэнийн Бямбажавыг зөвлөлийн гишүүнээс чөлөөлье гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/ Гишүүд анхааралтай байгаарай.

63.6 хувиар дэмжигдлээ.

Өмнө нь мөн ажиллаж байсан зөвлөлийн гишүүн Баярсайханы Баярдавааг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээс чөлөөлье гэсэн саналаар санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/ Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт.

63.6 хувиар дэмжигдлээ.

Мөн өмнө нь ажиллаж байсан зөвлөлийн гишүүн Атарбаатарын Энхжинг зөвлөлийн гишүүнээс чөлөөлье гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

54.5 хувиар дэмжигдлээ.

Өмнөх байсан зөвлөлийн гишүүдээс нэг гишүүн улирч орж ирж байгаа. Гэхдээ өмнөх нь орон тооны бус

байсан учраас чөлөөлөхөөс аргагүй байгаа.

Өмнө нь зөвлөлийн гишүүн байсан Ланганы Отгонтуяаг орон тооны бус Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүдээс чөлөөлье гэсэн саналаар санал хураалтыг явуулъя. /алх цохив/ Санал хураалт гишүүд анхааралтай байгаарай.

63.6 хувиар дэмжигдлээ.

Ингээд зөвлөлийн хараат бус гишүүнээр ажиллаж байсан Дамирангийн Сувдааг мөн хараат бус гишүүнээс нь чөлөөлье гэсэн саналаар санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

63.6 хувиар дэмжигдлээ.

Өмнө мөн хараат бус гишүүнээр ажиллаж байсан Гүнсэнгийн Алтанзаяаг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн хараат бус гишүүнээс чөлөөлье гэсэн саналаар санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

63.6 хувиар дэмжигдлээ.

Ингээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр орон тооны гишүүнээр томилуулах талаар санал хураалтыг явуулж эхэлье.

**Нэг.** Намжилдоржийн Энхбаярыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилуулах саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

63.6 хувиар дэмжигдлээ.

**Хоёр.** Жамсрандоржийн Дэлгэрсайханыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилуулах саналыг дэмжье гэсэн

томьёоллоор санал хураалтыг явуулъя.  
Санал хураалт. /алх цохив/

63.6 хувиар дэмжигдлээ.

**Гурав.** Нинжбатын Ууганбаатарыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилуулах саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

63.6 хувиар дэмжигдлээ.

**Дөрөв.** Амаржаргалын Энхбатыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилуулах саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

63.6 хувиар дэмжигдлээ.

**Тав.** Равсалын Ринчинбазарыг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилуулах саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

63.6 хувиар дэмжигдлээ.

**Зургаа.** Лхагважавын Гангэрэлийг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилуулах саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

63.6 хувиар дэмжигдлээ.

**Долоо.** Ланганы Отгонтуяаг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилуулах саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

63.6 хувиар дэмжигдлээ.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсгол явуулсан талаарх тайланг бүхэлд нь дэмжье гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт. /алх цохив/

63.6 хувиар дэмжигдлээ.

Ингээд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсгол явуулсан талаарх тайлан болон нэр дэвшигчийг томилох асуудлыг хэлэлцэж дууслаа.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч байснаар миний бие танилцуулъя.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг шинээр орон тооны болгон байгуулах асуудлыг Төсвийн байнгын хороо хэлэлцэж дууслаа.

Улсын Их Хурлаас анх удаагаа Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болоод бусад 14 хуульд хийсэн өөрчлөлтийн дагуу энэ зөвлөл маань байнгын орон тооны мэргэжлийн институт бий болох үндэс суурь өнөөдөр томилогдож байгаа зөвлөлийн гишүүдийн эрх зүйн орчны хүрээнд бий болж байна.

Тэгээд Та бүхэн цаашид улс төрөөс ангид байж, мэргэжлийн байх, хараат бус байдлаар мэргэжлийн судалгаа шинжилгээ хийж, Монгол Улсын төсөв, санхүү, тогтвортой байдал, ил тод байдлыг хангахын төлөө итгэл дүүрэн ажиллана гэдэгт итгэлтэй байгаа.

Та бүхэнд амжилт хүсье.  
Баярлалаа. /алга ташив/

Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүнээр томилох асуудлыг хэлэлцэж дууслаа.

Дараагийн асуудалдаа оръё. Нэг асуудал байгаа.

### Дөрөв. Байнгын хорооны тогтоолын төсөл

*/Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 01 дүгээр сард хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/*

Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 2024 оны 01 дүгээр сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Та бүхэнд цаглаварын төслийг бэлтгэн тараасан байгаа.

Цаглаварын төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Санал хэлэх гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

2024 оны 01 дүгээр сард Төсвийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. /алх цохив/

54.5 хувиар дэмжигдлээ.

Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж шийдвэрлэлээ.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Хуралдаанд идэвхтэй оролцсон нийт гишүүдээ баярлалаа. /алх цохив/

*Хуралдаан 55 минут үргэлжилж, 16 цаг 21 минутад өндөрлөв.*

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**ЦАЛТАН-ОД**